



МОНГОЛ ЭЦЭГ ЭХИЙН БОЛОВСРОЛ БА ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

СУДЛААЧ:

Ц.БАДАМХАТАН

**(Төрийн удирдлагын магистр, ХТХАА-ны
мэргэжилтэн)**

Танилцуулга

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тодорхойлсоноор (ILO), хүүхдийн хөдөлмөр гэдэг нь “хүүхдийг хүүхэд наснаас нь холдуулж тэдний боломж бололцоо, нэр хүндэд сөргөөр нөлөөлж биеийн болон оюун санааны хөгжилд нь саад болох ажлыг хэлнэ. Биеийн хүчний, оюун санааны, нийгмийн, ёс суртахууны хувьд аюултай ажлууд, сургуулаас завсардуулах, тасалдуулах, эсвэл хүнд хүчир ажлын хажуугаар сурах байдалд хүргэж буй ажлыг хэлнэ” гэжээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын судалсанаар дэлхий дээрх хүүхдүүдийн 11% нь төрөл бүрийн хэлбэрийн хүүхдийн хөдөлмөрт өртөж байна.

2014 онд UCW (Хүүхдийн хөдөлмөрийг ойлгох нь) хөтөлбөрийн тооцоолсоноор монголд 5–17 насны хүүхдүүдийн 9.6% нь (56,612 хүүхэд) хүүхдийн хөдөлмөр эрхэлж байна. НҮБ-ийн Хүүхдийн сангийн 2017 оны судалгаагаар энэ тоо нь 17% хүртэл өндөр байна. Түгээмэл эрхэлж буй ажлуудын төрөлд хөдөө аж ахуйн, хурдан морь унах, барилга, уул уурхайн ажлууд багтаж байгаа бөгөөд сүүлийн гурав нь аюул занал бүхий ажлын ангилалд багтаж байна. Хөдөө орон нутагт амьдарч буй хүүхдүүд хотын хүүхдүүдтэй харьцуулахад арав дахин их хөдөлмөр эрхэлж байгаа нь орлого багатай айлын хөвгүүд мал маллах, хурдан морь унах зэрэгтэй холбоотой байна. Хөвгүүд охидуудаас илүү хөдөлмөр эрхэлж байгаа нь боловсролын хувьд хүйсийн тэгш бус байдалд хүргэж байна (ILO, 2008). Хотын төвийн бүсээр хүүхдийн хөдөлмөр нь барилга болон уул уурхайн салбарын ажилд давамгайлж байна. Хөдөлмөрийн хуульд заасан цагийг хэтрүүлэн долоо хоногт ажилласан цаг нь дунджаар 60 ба түүнээс дээш байна (UCW, 2014). Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаагүй болон заавар зааварчилгаа өгөөгүйгээс болж осол гэмтэлд өртөх эрсдэл өндөр байна. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд ихэвчлэн бага орлоготой гэр бүлээс гаралтай байгаа бөгөөд тэдний эцэг эх нь хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дагаврын талаар ойлголтгүй, тэдний үзүүлж буй санхүүгийн тусламжид нь илүү анхаарч ач холбогдол өгч байна. Хотын бүсэд амьдарч буй хүүхдүүдийн орлогын эх үүсвэрийн нэг нь уул уурхайн салбар байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон Монголын Хүний Эрхийн Комиссын 2008 оны хамтарсан судалгаагаар уул уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн 63% нь өдөрт 6 ба түүнээс дээш цаг ажиллаж 73% нь ямар ч цагийн хуваарьгүй өглөөнөөс орой болтол өдөр бүр ажиллаж байна. 50-аас дээш хувь нь газар доор, бохирдол ихтэй болон дуу чимээтэй орчинд ажиллаж байна. Аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэл бараг хэрэглэхгүй байна. Нийт ажилласан хүүхдүүдийн талаас илүү хувь нь ажил дээрээ осолд өртөж, мөн тэр хэмжээний хүүхдүүд эрүүл мэндийн асуудалд орсон байна. Уул уурхайг бараадан ажил хайж шилжин суурьшиж буй бага орлоготой айлуудын хүүхдүүд энэ салбарт ажиллах эрсдэл өндөр байна.

Хүүхдийн нас бага байх тусмаа хүүхдийн хөдөлмөрийн биеийн болон сэтгэл санааны сөрөг үр дагаварт илүү хүчтэй өртөж байна. Тиймээс, хүүхэд илүү бага залуудаа хөдөлмөрийн зах зээлд оролцох тусам түүний боловсрол илүү их доройтож үр дүнд нь хүн капиталын хуримтлал бага явагдана. Монгол улсын 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 15-аас доош насны хүүхэд ажил эрхлэх хориотой бөгөөд зөвхөн эцэг эх, асран хамгаалагч, улсын зөвшөөрөлтэйгээр мэргэжлийн сургалт болон шавилан суралцах ажилд гэрээ хийх ажиллах боломжтой бөгөөд зөвхөн 16

ба түүнээс дээш настай хүүхэд хөдөлмөрийн гэрээнд оролцох эрхтэй. Хөдөлмөрийн хүнд нөхцөлтэй ажилд зөвхөн 18 ба түүнээс дээш настай иргэн оролцоно гэж заажээ.

Хэдийгээр хүүхдийн хөдөлмөр нь өрхийн орлогыг богино хугацаандаа нэмэгдүүлэх боловч урт хугацаандаа хүн капиталын хуримтлалыг бууруулсанаар ядуурлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог. Хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн хүчин чармайлт нь бодлого боловсруулагчдын анхаарах ёстой тэргүүний асуудлуудын нэг байх ёстой бөгөөд энэ нь дан ганц хүний эрхийн асуудал төдийгүй зохистой ажлын байр болон эдийн засгийн өсөлтийг дэмжсэнээр Тогтвортой Хөгжлийн Зорилт 8 буюу хүүхдийн хөдөлмөрийн хүнд хэлбэрийг хориглох, устгах, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх төрлийг арилгах зорилтод чиглэсэн үйл ажиллагаа болох юм.

Дээр дурьдсан мэдээллийг шалган туршиж мөн боломжит бодлогын зөвлөмжийг гаргахын тулд энэхүү судалгаагаар монгол улсын 18-аас доош насны хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийг ажилласан цаг болон нийгэм эдийн засгийн байдал, өрхийн орлого болон боловсрол гэх мэт хүчин зүйлстэй нь уялдуулан судаллаа.

Дата болон хураангуй статистик

Энэхүү судалгаа нь Монголын Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгаа 2014 (ӨНЭЗС)-ийн дата мэдээллийг ашиглана. ӨНЭЗС нь эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, өрхийн орлого, зарлага зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан улс даяар хийгддэг төлөөлөх чадвар өндөртэй мэдээллийн баазтай юм. ӨНЭЗС нь өрх, хувь хүн болон хүүхдийн асуумжуудтай бөгөөд 16,174 өрхийн 58,852 хүнийг санамсаргүй түүврийн аргаар хот болон хөдөө орон нутгаас ижил тоотойгоор сонгон асуулгад хамруулсан. Энэхүү судалгаанд хүүхдийн дата бааз буюу зургаагаас арван найман настай 13,502 хүүхдийн мэдээллийг өрхийн болон эдийн засгийн нөхцөл байдлын мэдээлэлтэй нь холбон ашиглалаа. Өрхийн ерөнхий болон нийгэм эдийн засгийн үзүүлэлтэд төрсөн огноо, хүйс, амьдарч буй газар, гэр бүлийн гишүүдийн тоо, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн нарийн үзүүлэлт болох өмнөх долоо хоногт ажилласан цаг зэрэг хувьсагчдыг оруулан судаллаа.

Хураангуй статистикийг Хүснэгт 1–д харуулав. Тооцоололд нийт 6,162 хүүхэд хамрагдсан бөгөөд өнгөрсөн долоо хоногт ажилласан цаг нь хамгийн багадаа 0 хамгийн ихдээ 84 байсан байна. Дундаж нас нь 11.7. Хөвгүүд түүврийн 50 хувийг эзэлж байна. Тооцоололд хамрагдсан нийт хүүхдүүдийн 96 хувь нь сургуульд хамрагдсан. Хотод амьдардаг хүүхдүүд түүврийн 24.4 хувийг эзэлж байна. Өрхийн жилийн дундаж орлого нь 8,358,260 төгрөг буюу 3,200 америк доллар. Гэр бүлийн гишүүдийн тоо дунджаар 5 байна. Эцэг эхийн боловсролын зэргийг категори хувьсагчаар буюу 1–10 гэсэн тоогоор суралцсан жилийн өгсөх үзүүлэлтээр харууллаа. Бакалавр зэрэгтэй эцэг түүврийн 11.9 хувь байхад ижил зэрэгтэй эх 19.4 хувь байна. Эмэгтэйчүүд мөн магистрийн зэрэг эзэмшилтийн хувиар эрэгтэйчүүдийг тэргүүлж байна.

Хүснэгт 1. Хураангуй статистик

Хувьсагчид	Дундаж	Стандарт хазайлт	Минимум	Максимум
Ажилласан цаг	0.409	4.81	0	84
Нас	11.691	3.76	6	18
Хүйс	0.504	0.5	0	1
Сургуульд хамрагддаг	0.965	0.18	0	1
Хотод амьдардаг	0.244	0.43	0	1
Өрхийн жилийн орлого	8358260	6102046	50000	62200000
Гэр бүлийн гишүүдийн тоо	5.054	1.35	2	13
Эцгийн боловсролын зэрэг				
Боловсролгүй	0.023	0.15	0	1
Бага	0.054	0.23	0	1
Дунд	0.18	0.38	0	1
Суурь	0.327	0.47	0	1
Мэргэжлийн	0.142	0.35	0	1
Тусгай	0.066	0.25	0	1
Дипломын дээд	0.072	0.26	0	1
Бакалавр	0.119	0.33	0	1
Мастер	0.013	0.12	0	1
Доктор	0.002	0.04	0	1
Эхийн боловсролын зэрэг				
Боловсролгүй	0.012	0.11	0	1
Бага	0.032	0.18	0	1
Дунд	0.153	0.36	0	1
Суурь	0.314	0.46	0	1
Мэргэжлийн	0.084	0.28	0	1
Тусгай	0.091	0.29	0	1
Дипломын дээд	0.093	0.29	0	1
Бакалавр	0.194	0.39	0	1
Мастер	0.023	0.15	0	1
Доктор	0.0009	0.031	0	1
Нийт түүвэр				6162

Тооцооллын аргачлал

Энэхүү судалгаа нь тооцооллын Тобит моделийг ашиглан хүүхдийн ажилласан цагт эцэг эхийн боловсролын зэрэг хэрхэн нөлөөлж байгааг судаллаа. Тайлбарлуулагч хувьсагч нь тэг болон түүнээс дээш тооны утга авч байгаа бөгөөд хязгаар нь тэгээс 84 хүртэл байгаа

тул латент хувьсагчийн онолд тулгуурласан Тобит модел нь илүү алдаагүй нарийвчилсан тооцооллыг хийх боломжтой. Дараах моделийг тооцоололд ашиглалаа:

$$Y_i = \beta_0 + \beta_1 E_i + X_i' \beta_2 + u_i$$

Үүнд Y_i нь тайлбарлуулагч хувьсагч – өнгөрсөн долоо хоногт ажилласан цаг, E_i эцэг эхийн боловсролын зэрэг, X_i' нь бусад хувьсагчид: нас, хүйс, амьдарч буй байршил, сургуульд хамрагдалт, гэр бүлийн гишүүдийн тоо, орлого бөгөөд u_i нь хомоскедастик нормал тархалттай алдаа гэж үзэв.

Тобит модел нь латент хувьсагчийн онолыг ашигладаг тул коэффициентүүдийг тайлбарлахдаа эерэг утгатай хариунуудын дундажын Дундаж хэсэгчилсэн нөлөө болон тэгийг оролцуулсан бүх эерэг утгатай хариунуудын дундажын Дундаж хэсэгчилсэн нөлөөг тооцоолон хүснэгтэд харуулсан болно.

Хариу болон хэлцэмж

Хүснэгт 2–т тооцооллын хариуг харуулав. Багана (1)–т OLS (хамгийн бага квадратын арга) хариуг, багана (2)–т эерэг утгатай хариунуудын ДХН (дундаж хэсэгчилсэн нөлөө), багана (3)–т тэгийг оролцуулсан бүх эерэг утгатай хариунуудын ДХН-г харуулсан болно. Тооцооллын хариунаас харахад хүүхдийн нас ихсэх тусам ажиллах цаг нь өсч байгаа нь харагдаж байна. Хэрэв хүүхэд эрэгтэй бол ажиллах цаг нь 1.7-гоор нэмэгдэж байна. Хэрэв хүүхэд сургуульд явдаг бол ажиллах цаг нь 7-гоор буурч байна (99% үнэн магадлалтай). Энэхүү судалгаагаар хот, хөдөөгийн хүүхдүүдийн ажиллах цагийн хоороонд мэдэгдэхүйц ялгаа илрээгүй байна. Өрхийн орлого нь хүүхдийн ажиллах цагтай сөрөг хамааралтай байна.

Маш сонирхолтой нь эхийн боловсролын зэрэг хүүхдийн хөдөлмөр эрхлэх цаг хоёрын хооронд ямар нэгэн хамаарал илрээгүй байна. Харин эцгийн боловсрол хүүхдийн хөдөлмөр эрхлэх цагт мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн байна. Хүснэгтээс харахад хэрэв эцгийн боловсролын зэрэг нэг түвшнээр нэмэгдвэл хүүхдийн ажиллах цаг 0.98-р багасна гэдгийг 99%-ийн үнэн магадтайгаар хэлж болохоор байна. (Жич: регресс анализ хийхдээ эцэг эхийн боловсролыг үргэлжилсэн хувьсагчруу шилжүүлэн тооцоолсон болно.)

Хүснэгт 2. Тооцооллын хариу

Тайлбарлах Хувьсагчид	(1) OLS	(2) Тобит APE for positive outcomes	(3) Тобит APE for all outcomes
Нас	0.166*** (0.0159)	0.838*** (0.200)	0.119*** (0.0225)
Эрэгтэй	0.327*** (0.118)	1.766*** (0.744)	0.251*** (0.0964)
Сургуульд хамрагддаг	-6.357***	-6.939***	-0.984***

	(0.326)	(1.880)	(0.160)
Хотод амьдардаг	0.0411 (0.142)	0.772 (0.797)	0.109 (0.114)
Өрхийн орлого	-5.24e-09 (1.15e-08)	-0.000000115 (7.62e-08)	-1.64e-08 (1.22e-08)
Гэр бүлийн гишүүдийн тоо	0.00748 (0.0451)	0.121 (0.191)	0.0171 (0.0272)
Эхийн боловсролын зэрэг	-0.0386 (0.0389)	-0.0649 (0.220)	-0.00921 (0.0309)
Эцгийн боловсролын зэрэг	-0.140*** (0.0409)	-0.982*** (0.321)	-0.139*** (0.0409)
Констант	5.291*** (0.477)		
Нийт түүвэр	6162	6162	6162
<i>Хаалтад стандарт алдааг харуулсан болно.</i>			
<i>*p<0.10, **p<0.05, ***p<0.01</i>			

Эцгийн боловсролоор дамжуулан хүүхдийн ажиллах цагт нөлөөлж болох хоёр суваг байж болох юм. Нэгдүгээрт, орлогын суваг: боловсрол өндөртэй эцгийн орлого өндөр байх магадлалтай бөгөөд энэ нь өрхийн орлогыг нэмэгдүүлэх тул хүүхэд хөдөлмөр эрхлэх шаардлага бага байж болох юм. Хоёрдугаарт, боловсролын суваг: эцэг нь өндөр боловсролтой байх тусам боловсролын үнэ цэнийг эрхэмлэх нь илүү бөгөөд хүүхдээ сургуульд явуулахыг илүүд үзэх ба хүүхэд сургуульд явсанаар хөдөлмөр эрхлэх цаг нь багасаж болох юм. Түүнчлэн, эхийн боловсролын зэрэг хүүхдийн хөдөлмөр эрхлэх цагтай ямар нэгэн хамаарал илрээгүй нь эмэгтэй хүний байгалиасаа хүүхэд тээж төрүүлэх, асрах, улмаар хөдөлмөрийн зах зээлээс урт хугацаагаар тусгаарлагдах зэрэг шалтгаантай хамааралтай байж болохоос гадна монгол орны хөдөлмөрийн зах зээл дээр эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрэгтэйчүүдийнхээс бага үнэлэгддэг байхыг мөн үгүйсгэхгүй юм. Энэ чиглэлээр мөн гүнзгийрүүлсэн судалгаа хийгдэх шаардлага, хэрэгцээ харагдаж байна.

Дүгнэлт

Хүүхдийн хөдөлмөр нь хүний эрхийг зөрчсөн ноцтой үйлдэл бөгөөд хүүхдийг боловсрол болон эрүүл мэндээс нь холдуулахаас гадна ядуурлыг бэхжүүлэгч хүчин зүйл болдог. Хувь хүн төдийгүй өрхийн, макро эдийн засгийн түвшинд сөрөг нөлөө үзүүлсэнээр эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийг бууруулдаг.

Монгол улс нь хүний эрхийг хангах, олон улсын хөдөлмөрийн зах зээлийн стандартыг мөрдөхийн тулд хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлэх, түүнийг устгахад чиглэсэн

үйл ажиллагаагаа эрчимжүүлэх хэрэгтэй байна. Хүүхдүүд, эцэг эхчүүд, хүүхдэд хөдөлмөр олгогчид болон багш нарт хууль эрх зүйн болон хүүхдийн хөдөлмөрийн, түүний хүнд хэлбэрүүд, хорт үр дагавруудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд мөн хувь хүний хөгжлийн төлөө тасралтгүй боловсрол эзэмших нь урт хугацааны санхүүгийн хүндрэлээс сэргийлэх чухал хүчин зүйл болохыг ойлгуулан, сурталчлах шаардлага байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад хөвгүүд болон тэдгээрийн эцгүүдийг чиглэсэн арга хэмжээ авч тэдний боловсролыг дээшлүүлэхэд, хүүхдийн хөдөлмөрийг бууруулж улмаар ядуурлыг багасгаж болохоор харагдаж байна. Урт хугацааны туршид монгол улсын нийгмийн соёл нь хөвгүүдийнхээс илүү охидынхоо боловсролд анхаарсаар иржээ. Гэр бүлүүд охидоо сургуульд боловсрол эзэмшүүлэхээр явуулж харин хөвгүүд ахуйн болон бусад олон төрлийн хүнд хүчир ажил эрхлэх нь элбэг байна. Энэ тогтсон хэвшлийг өөрчилж эрэгтэйчүүдийг өндөр боловсрол эзэмшүүлэхээр сорих хэрэгцээ, шаардлага байгаа бөгөөд ингэснээр дан ганц хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн сөрөг үр дагавар төдийгүй нийгмийн бусад олон асуудлыг шийдвэрлэх боломжтой харагдаж байна.

Ном зүй

1. Retrieved from <http://ilo.org/ipecc/facts/lang--en/index.htm>
2. Retrieved from https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_491324.pdf
3. Retrieved from <https://data.unicef.org/topic/child-protection/child-labour/>
4. Understanding Children's Work (UCW): *The twin challenges of child labour and educational marginalisation in the South-East and East Asia region: an overview* (Rome, UCW, 2014), p. 6.
5. ILO International Programme on the Elimination of Child Labour (IPEC) and National Human Rights Commission of Mongolia (NHRCM): *The worst forms of child labour in Mongolia – Study report* (Geneva, ILO, 2008), pp. 75–76.